

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАРААНЫ КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д.Батцэцэг* Н. Оюунжаргал**

Хураангуй: Орчин үед дэлхийн улс орнуудын компаниуд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, нэмүү үнэ цэнийг бий болгохын тулд маш их анхаарч гарааны компани хөгжүүлэх талаар бодлогын хэмжээнд чухалчлан авч үзэж байна. Өнөөгийн мэдлэг мэдээллийн нийгэмд хуучны уламжлалт компанийн талаарх ойлголт, менежментийг хэрэгжүүлэх арга барилууд ч өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага бий болж байгаа бөгөөд гарааны компани, гарааны бизнес менежмент хэмээх шинэ ойлголтууд бий болж байгаа нь бодит үнэн билээ.

Иймээс аж үйлдвэрийн нийгэм, эдийн засаг, боловсролын системийг мэдлэгт суурилсан шинэ парадигмд нийцүүлэн өөрчлөхийг шаардаж байна. Монгол улсад Гарааны бизнесийн хөгжил эрт үе дээрээ байгаа төдийгүй, гарааны компаниуд шинээр бий болж үйл ажиллагаагаа явуулаад удаагүй тэдний хувьд мэдлэг, туршлага, бизнесээ авч явах нөхцөл байдал хараахан төлөвшөөгүй, мөн энэ салбарын нэр томъёоны хувьд ч нэгдмэл ойлголтод хүрч чадаагүй байгаа билээ. Энэхүү судалгаагаар манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа Гарааны компаниудын өнөөгийн байдлыг тодорхойлж, тэд гарааны компанийн мөн чанарыг хадгалж байгаа эсэхийг илрүүлж үнэлгээ, дүгнэлт өгөхийг зорьлоо.

Түлхүүр үгс: гарааны компани, энтрепренер, венчур хөрөнгө оруулалтын компани

Оршил

Гарааны бизнес /start-up/ бизнесийн түүхээс үзвэл 1947 оноос АНУ-аас эхтэй бөгөөд 1970 он гэхэд цэцэглэлт хөгжлийн оргил үе байлаа. Энэ үед венчур хөрөнгө оруулалт бүхий компаниуд олноор үүсгэн байгуулагдаж

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) dalhbattseteg@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) aikang_mongkor@yahoo.com

байсан бөгөөд гол төлөөлөгч бол АНУ-ын Санфранциско хотын өмнө зүгт байрладаг “Silicon valley” юм. Эндээс дэлхийд алдартай маш олон компаниуд амжилтын гараагаа эхэлсэн байдаг. Жишээлбэл: Cisco, Applied Materials гэх мэт. Эдгээр компаниуд АНУ-ын нийгэм эдийн засгийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэн улсын хөгжлийг хурдасгагч гол хүчин зүйл нь болж байв. Гэвч гарааны компаний амжилтанд хүрэх магадлал 5%-иас хэтэрдэггүй болохыг 1970 оны АНУ-ын эрдэмтдийн гаргасан судалгаагаар харуулжээ. Энэ утгаараа гарааны компани нь гэдэг нь аз туршсан, эрсдэл дагуулсан гэх утгыг агуулж байдаг.

Гарааны компанийг “Өндөр технологи-мэдлэгт суурилсан жижиг дунд бизнес”, “Судалгаанд суурилсан жижиг дунд бизнес” гэх мэт нэрлэж байгаа бөгөөд улс орон бүр өөрийн онцлогт тохируулан тодорхойлж байгаа учраас нэгдсэн нэг ойлголтонд хүрээгүй байна. Гэхдээ гол мөн чанар, агуулгыг нэгтгэн үзвээс “Өндөр технологи бүхий шинэ санааг хөгжүүлж бизнесийн эргэлтэнд оруулдаг, ирээдүйн өсөлт өндөртэй жижиг, дунд бизнес” гэж үзэж болох юм.

АНУ-ын жижиг дунд бизнесийн хөрөнгө оруулалтын тухай хуулинд гарааны компанийг “Аюул эрсдэл их боловч, их ашиг олох боломж бүхий шинэ компани /new business with high risk –high return/, Өндөр технологи бүхий жижиг дунд бизнес /high –technology small business /” гэж тодорхойлжээ.

Японы жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулинд гарааны компанийг “Судалгаа хөгжилд суурилсан компани”, “технологит суурилсан компани” гэж тодорхойлсон байна.

БНСУ-ын гарааны компанийг “вэнчур компани” гэж тодорхойлоод эдгээр компанийг дэмжих тухай хуулинд “Хувь хүн болон цөөхөн тооны үүсгэн байгуулагчтай, аюул эрсдэл их боловч амжилтанд хүрэх магадлал өндөр, их ашиг орлогыг бий болгох шинэ технологи, шинэ санааг бизнесийн эргэлтэнд оруулах зорилгоор байгуулагдсан жижиг, дунд бизнесийн байгууллага” гэж тодорхойлжээ. Мөн дараах нөхцлүүдийг аль нэгийг хангасан ЖДБ-ийн байгууллагыг “вэнчур компани” гэж гээд дотор нь 4 ангилсан байдаг. Үүнд :

- **Вэнчур хөрөнгө оруулалт бүхий компани:** Хөрөнгө оруулалтын компани, шинэ технологийн бизнесийг дэмжих санхүүгийн байгууллага, вэнчур хөрөнгө оруулалтын холбоо гэх мэт байгууллагуудаас хувьцааны 10-аас дээш хувийн хөрөнгө оруулалт авсан компани
- **Судалгаа хөгжлийн хөрөнгө оруулалтын компани:** Судалгаа

хөгжилд нийт борлуулалтын 5%-аас дээш хувийг хөрөнгө оруулалт хийсэн компани

- **Шинэ технологи хөгжлийн компани:** Патент ашигт загварын гэрчилгээ гэх мэт технологи хөгжлийн бизнест тулгуурласан борлуулалтын хэмжээ нь нийт борлуулалтын 50% —иас дээш хувийг эзэлсэн компани, экспортын борлуулалтын хэмжээ 25%-иас дээш компани
- **Технологи үнэлгээний компани:** Вэнчур компаний үнэлгээний байгууллагаас технологи болон арилжаалагдах чадамж өндөр гэсэн үнэлгээ авсан компани

Гарааны компаниудын онцлог

Гарааны компани нь дараах онцлогтой байна.

- Үүсгэн байгуулагч буюу энтрепренер нь технологийн хувьслыг шинэ санаа болгон бизнесийн эргэлтэнд оруулахын тулд байгуулсан шинэ компани. Энэ утгаараа технологид суурилсан компани гэж үздэг;
- Өндөр аюул эрсдэлтэй ч амжилт олох тохиолдолд маш их хэмжээний ашиг орлого бий болгох төлөвтэй;
- Энтрепренер нь аз туршсан бизнест зориг шулуудан орох хүсэл эрмэлзэлтэй;
- Судалгаа хөгжилд суурилсан хэлбэртэй, мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлэхэд голлох үүрэгтэй;
- Судалгаа хөгжлийн зардал өндөртэй;
- Үүсгэн байгуулагч буюу энтрепренер нь нарийн технологийн мэдлэгтэй төдийгүй, ажиллагчдын ихэнх хувийг нарийн мэргэжлийн хүмүүс эзэлдэг;
- Том компаний хүнд суртлын зохион байгуулалтаас өөр динамик зохион байгуулалттай;
- Борлуулалтын хэмжээ болон ажлын байрны өсөлт өндөр г.м

Мөн гарааны компаниуд нь дэвшилтэд шинэ технологийг үндэс сууриа болгодог учраас улсын хөгжлийн эх үүсвэр болдог. Дараах ач холбогдолтой байдаг. Үүнд:

- Баялаг бий болгох
- Ажлын байр бий болгох
- Нөөцийг ашиглах
- Амьдралын орон зайг ашиглах
- Шинжлэх ухааны технологийн хөгжлийг хурдасгах

Хүснэгт 1. Амжилтанд хүрсэн гарааны компаниудын онцлог

Энтрепренерын онцлог шинж	Үйлдвэрлэлийн салбарын онцлог	Хэрэгжүүлж буй стратеги	Компаний онцлог
<ul style="list-style-type: none"> • Өндөр боловсрол-той • Мэргэжлийн технологи эзэмшигч • Аюул эрсдлийг даван туулах сэтгэлийн тэнхээтэй , зорьсноо биелүүлэх чин хүсэлтэй • Оюутан байхдаа төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай 	<ul style="list-style-type: none"> • Хөгжиж буй аж үйлдвэрийн салбар • Технологийн өрсөлдөөн хүчтэй, өөрчлөлт хурдан явагддаг • Дотоодын өсөлтийн бус шатанд буй зах зээл 	<ul style="list-style-type: none"> • Эхэндээ завсрын зах зээлд төвлөрдөг • Бага үнэлгээий бодлоготой /ялгарах стратеги / • Гадны дэмжлэгийг авдаг • Нийт борлуулалтын 10 –аас дээш хувийг судалгаа хөгжилд хөрөнгө оруулдаг • Аюулгүй бэхлэлт хийсний дараа бизнесийн хүрээгээ тэлдэг 	<ul style="list-style-type: none"> • Менежментийн философи нь хүчтэй • Олон нийтэч соёлыг бий болгодог • Мэдээлэл солилцдог, уян хатан харилцаатай • Ажил үүргээ гүйцэтгэх чөлөөт эрх мэдэл өндөр • Оролцооны системд тулгуурласан • Ашгаа хуваалцдаг, сайн нөхөн олговрын бодлоготой

Хүснэгт 2. Энтрепренерын онцлог, мөн чанар

Итгэл үнэмшил	Шийдэмгүй, овсгоо самбаатай , золиос гаргах сэтгэлтэй, боломжийг эрэлхийлдэг.
Манлайлал	Идэвхи санаачлагатай, бусдад зөвлөдөг, урамшуулдаг, хамтран ажиллагчиддаа шударгаар ашгийг хуваариладаг, итгэл хүлээлгэдэг.
Аюул эрсдэлийг даван туулах болон тодорхой бус байдалд дасан зохицох чадвар	Гэнэтийн аюул эрсдлийг даван туулах тэсвэр тэвчээртэй, түүнийг боломж болгон ашиглах чадвартай , стресс болон зөрчил зөрөлдөөн, тодорхой бус байдалд дасан зохицох чадвартай, өөрчлөлтөнд хурдан зохицдог.
Сэтгэн бодох чадвар	Бүтээлчээр асуудалд ханддаг, шинийг эрэлхийлдэг
Хамгийн шилдэг байхыг хүсдэг	Зорилго ба үр дүнд чиглэсэн, албан тушаал ба эрх мэдлийг үл сонирхдог, бусадтай хамтрах дуртай, хэрсүү, хошин шогийн мэдрэмжтэй.

Гарааны компаниудын соёл

Хурд	Өрсөлдөөнд ялахын тулд хурдыг чухалд үздэг. Энгийн компанид тухайн нэг асуудлыг шийдэж төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 1 жил байдаг бол вэнчур/гарааны/ компани 3-6 сарын дотор хэрэгжүүлэх жишээтэй. Тэд хурдтай байхын тулд өдөр шөнөгүй ажиллах ба төслийн хугацаа дуусвал амралтаа авдаг байна.
Алтан өндөг ба эрх чөлөө	Гарааны компаниудын хувьд шинэ санаа хаан юм. Үүсгэн байгуулагч болон нийт ажиллагчид шинэ санааг гаргаж байх ёстой байдаг. Шинэ санааг амжилттай хэрэгжүүлвэл алтан өндөг төрнө гэж үздэг бол эсрэгээр амжилтгүй болох үед тухайн ажилтанд ямар нэгэн шийтгэл өгч тооцоо бодохгүй харин ч эрх чөлөөг эдлүүлдэг байна.

Эмх цэгцгүй замбараагүй байдал	Шинэ санаа амжилтгүй болсон ч тухайн ажилтантай ямар нэгэн тооцоо бодохгүй эрх чөлөөтэй байлгадаг нь эмх цэгцгүй замбараагүй байгаа мэт харагдуулдаг. Мөн шинэ санаанууд хоорондоо зөрчилдөх явдал гарах төдийгүй хэлтэс хоорондын ажил үүргийн хуваарилалт тодорхой бус байдаг. Зарим тохиолдолд хэлтэс хоорондын ажил үүргийн уялдаа холбоо байхгүй стратеги ч байхгүй мэт харагддаг. Гэхдээ энэ нь тэдний стратеги бөгөөд соёл нь юм.
Багийн ажил ба сүлжээ	Гарааны компаний ажиллагчид хэлбэрдсэн байдалд дургүй байгууллагын нүсэр бүтцээс зайлсхийдэг хувь хүн бие даасан байдалтай байдаг. Харин сонирхолтой нь тэд багаар ажиллахад чадваржиж байдаг. Шаардлагатай тохиолдолд хэнтэй ч хамтран ажилладаг.
Идэвхтэй дэмжлэг шагнал урамшуулал	Шинэ санаа гарган амжилттай хэрэгжүүлсэн хүнд шагнал урамшуулал өгдөг, энэ нь мөнгөн шагнал байх бөгөөд ихэвчлэн зах зээл дээр өндөр үнээр зарагдах хувьцааг санал болгодог. / Хувьцаа эзэмших , хөрөнгийн оролцоо /
Хэрэглэгчийн сэтгэл ханамж	Нийт зах зээлийг боддоггүй . Тэд зорилгот зах зээлээ чухалд авч үздэг. Цөөн хэдэн хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бүтээгдэхүүн гаргаж сайжруулан хөгжүүлдэг.
Эрхэм зорилго ба үнэ цэнэ	Гарааны компани бүтэц хэмжээний хувьд бага ч маш том эрхэм зорилготой, дэлхийн хамгийн шилдэг нь байна гэсэн өндөр итгэл үнэмшилтэй байдаг. Тэд ёс зүйтэй байх, чин сэтгэлээсээ байх, үнэн шударга байх, бүтээлч санаачлагатай байх зэргийг байгууллагын үнэт зүйлээр сонгодог. Ийм эрхэм зорилго, итгэл үнэмшил, үнэт зүйл нь эмх цэгцгүй замбараагүй байдлыг эмх цэгцтэй болгож утга учиртай болгож өгдөг байна.

Монгол улс дахь гарааны компаниудын өнөөгийн байдал (2017 оны 4-р сард авсан судалгаагаар)

МУ-ын гарааны компаниудын өнөөгийн байдлыг судлахын тулд БШСУЯ-нд бүртгэлтэй 32 гарааны компаниудыг төлөөлөл болгож 24 компанийн үүсгэн байгуулагч нараас санал асуулгын аргаар судалгаа авлаа. Судалгаа маань 7 бүлэг бүхий 35 асуулгатай.

1-р бүлэг асуултууд нь гарааны компаниудын үйл ажиллагаа, өмчлөлийн хэлбэр;
2-р бүлэг асуултууд нь гарааны компаниудын шинэ патент эзэмшиж буй байдал, оюуны өмч;

3-р бүлэг асуултууд нь гарааны компаниудын ажиллах хүчний бүтэц, өсөлт;

4-р бүлэг асуултууд нь гарааны компаниудын борлуулалтын орлого, хөрөнгийн өсөлт, экспортын байдал;

- 5-р бүлэг асуултууд нь судалгаа хөгжил, хамтын ажиллагааны хэлбэр;
 6-р бүлэг асуултууд нь гарааны компаниудын соёлын түвшин;
 7-р бүлэг асуултууд нь энтрпренерүүдийн ур чадвар, манлайлал зэргийг тус тус тодорхойлох зорилготой байлаа.

- 1. Гарааны компаниудын үйл ажиллагааны төрөл:** Манай улсад үйл ажиллагаа явуулж буй гарааны компаниудын ихэнх нь газар тариалан, биотехнологийн чиглэлийн бизнес эрхэлдэг байна.

Хүснэгт 3.

Ангилал	Мал аж ахуй	Газар тариалан	Хөнгөн үйлдвэр	Мэдээлэл технологи	Эрүүл мэнд	Хүнсний үйлдвэр	Бусад	Нийт
Компаний тоо	3	9	2	2	3	3	2	24
Эзлэх хувь	12.5	37.5	8.3	8.3	12.5	12.5	8.4	100.0

Хүснэгт 4.

Өмчлөлийн хэлбэр			Санхүүжилтийн эх үүсвэр		
Хөрөнгө оруулалт	Тоо хэмжээ	Эзлэх хувь	Эх үүсвэр	Тоо хэмжээ	Эзлэх хувь
Дотоодын хөрөнгө оруулалттай	22	91.6	Төр, ЗГ-ын санхүүжилт	11	45.8
Гадаадын хөрөнгө оруулалттай	-	-	Хөрөнгө оруулагч хувь хүн	4	16.6
Холимог	2	8.4	Өөрийн хөрөнгө	8	33.4
			Бусад	1	4.2
Нийт	24	100.0		24	100

- 2. Гарааны компаниудын патент эзэмшиж буй байдал, оюуны өмч**
 Гарааны компаниуд нь шинэ технологит суурилсан шинэ санаа бүхий бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг. Ингэхдээ шинэ бүтээгдэхүүнээ оюуны өмчөөр баталгаажуулж патентжуулсан байдаг. Судалгаанд оролцсон компаниудын 16 нь 2 хүртэл жил, 8 компани 2-5 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тэдний 89.5% нь шинэ патент эзэмшдэг бол 10.5% нь патент эзэмшигч биш байна. Технологийн түвшний хувьд дунд түвшний технологи давамгайлж байна.

Хүснэгт 5.

Эзэмшиж буй оюуны өмчийн төрөл
Давхардсан тоогоор

Төрөл	Тоо хэмжээ
Барааны тэмдэг-брэнд	5
Патент, шинэ бүтээл	13
Ашигт загварын гэрчилгээ	3
Бүтээгдэхүүний загвар	5
Программ хангамж	1
Лиценз эзэмшигч	3

Эзэмшиж буй оюуны өмчийн тоо

Эзэмшиж буй өмчийн тоо	Тоо хэмжээ
1	16
2	3
3	2
4	-
5	2

Хүснэгт 6. Технологийн түвшин

Технологи	Тоо хэмжээ	Эзлэх хувь
Өндөр	6	25%
Дунд	11	45.8%
Нам	5	20.8%
Мэдэхгүй байна	2	8.4%
Нийт	24	100.0

Ажиллах хүчний бүтэц, өсөлт

Гарааны компаний үүсгэн байгуулагч буюу энтрепренер нь нарийн технологийн мэдлэгтэй төдийгүй, ажиллагчдын ихэнх хувийг нарийн мэргэжлийн хүмүүс эзэлдэг онцлогтой. Судалгаанд оролцсон гарааны компаниудын хувьд энэ онцлогийг хангахуйц үр дүн харагдаж байна.

Хүснэгт 7. Ажиллах хүчний бүтэц

№	Ангилал	Тоо
1	Доктор	25
2	Магистр	26
3	Бакалавр	40
4	Судалгааны ажилтан	22
5	Технологийн нарийн мэргэжилтэй ажилчид	27

Гарааны компаниудын өсөлтийн хувь:

Гарааны компани хэдий эрсдэл ихтэй боловч эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгож чадсан тохиолдолд борлуулалтын орлого болоод ажиллах хүчний өсөлтийн хувь өндөр байдаг. Манай гарааны

компаниудын хувьд борлуулалтын орлогын өсөлт, хөрөнгийн өсөлт, ажиллах хүчний өсөлт тун бага байгаа нь гарааны компаний өндөр өсөлттэй гэсэн үзүүлэлтийг хангаж чадахгүй байна.

Хүснэгт 8. Гарааны компаниудын өсөлтийн хувь

	Ажиллах хүчний өсөлт	Оюуны өмчийн өсөлт	Борлуулалтын орлогын өсөлт	Хөрөнгийн өсөлт	Экспортын өсөлт
Хувь	1%	2%	7%	3%	-

Судалгаа хөгжил, хамтын ажиллагаа

Гарааны компаниуд нь өндөр технологит суурилсан байдаг учир борлуулалтын орлогын тодорхой хувийг судалгаа хөгжилд зарцуулж технологийн хөгжүүлэлтийг байнга хийж байх онцлогтой бөгөөд их сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг. Судалгааны энэ хэсэгт Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гарааны компаниуд их сургууль, судалгааны байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж байгааг тодорхойлохыг зорьлоо. Судалгаанд оролцсон 24 компанийн 12 нь буюу 50% нь судалгаа хөгжилд борлуулалтын орлогын тодорхой хувийг зарцуулдаг болох нь судалгаагаар илэрсэн. Үүнийг задаргааг харуулбал:

Хүснэгт 9. Борлуулалтын орлогоос судалгаа, хөгжилд зарцуулж буй зардал /хувиар/

Борлуулалтын орлогоос зарцуулж буй хувь	1-5%	6-10%	11-15%	15-25%	26-30%	30-дээш	Нийт
Компанийн тоо	2	3	2	2	1	2	12/24
Хувь	8.3%	12.5%	8.3%	8.3%	4.2%	8.3%	50/100

Технологи хөгжүүлэлтийн тухайд манай улсын Гарааны компаниудын 36,8% нь эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Хүснэгт 10. Технологи хөгжүүлэлт

Эх үүсвэрүүд	Хувь
Өөрийн лабортори дээр түшиглэдэг	26.3%
Их дээд сургуулиудтай хамтран ажилладаг	10.5%
Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг	36.8%

Гадаад орны экспертүүдтэй хамтран ажилладаг	-
Зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай хамтардаг	5.3%
Мэдэхгүй	21.2%

Гарааны компаниудын их сургууль болоод томоохон компаниудтай хэрхэн хамтран ажилладаг болохыг судалгааны дараах үр дүнгээр харуулав.

Хүснэгт 11.

Гарааны компаниуд Их дээд сургуулиудтай хамтран ажиллаж буй хэлбэр

Хамтын ажиллагааны хэлбэрүүд	Хувь
Хамтарсан төсөл хэрэгжүүлдэг	15.8%
Эрдэмтэн профессоруудаас зөвлөгөө авдаг	5.3%
Захиалгат ажил хийлгэдэг	5.3%
Бүтээгдэхүүн хөгжүүлдэг	26.3%
Шинэ бүтээлийн туршилт хийдэг	10.5%
Сургалт авдаг	5.3%
Хамтын ажиллагаа байхгүй	31.6%

Том компаниудтай хамтран ажиллаж буй хэлбэр

Хамтын ажиллагааны хэлбэрүүд	Хувь
Санхүүгийн дэмжлэг авдаг	10.5%
ТЭМ сэлбэг худалдан авдаг	15.8%
ТЭМ, сэлбэг нийлүүлдэг	5.3%
Хамтран технологи хөгжүүлдэг	21.1%
Оюуны өмч технологи харилцан солилцдог	10.5%
Бусад	10.5%
Хамтын ажиллагаа байхгүй	26.3%

Гарааны компаниудын соёлын түвшин

Гарааны компани өөрийн гэсэн онцлог соёлтой байдаг. Энэ нь компанийн ажилчид шинийг эрэлхийлдэг, чөлөөт сэтгэлгээ, шинэ санааг эрхэмлэдэг, хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй, маш том зорилгын төлөө нэгддэг г.м онцлогтой. Эдгээр соёлын онцлог шинж манай гарааны компаниудад хэрхэн илэрч байгааг тодруулахаар Лайкертын 1-5 шкалыг ашиглан хэмжиж дескриптив анализ хийж үзэхэд үзүүлэлтүүдийн дундаж утга 3.06-3.93, стандарт хазайлт 0.5-1.1 байна. Үзүүлэлтүүд дотроос компанийн соёлын хувьд шинэ зүйлийг байнга эрэлхийлдэг 3.93, компанийн ажилчид багаар ажиллах дуртай 3.81, ажилтан бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг 3.62 гэсэн дундаж утга бүхий үр дүн гарсан.

Хүснэгт 12. Компанийн соёлын түвшин

Шалгуур үзүүлэлтүүд	N	Mean	Std. D
Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт хурдан	22	3.06	.798
Өөрчлөлт шинэчлэл байнга хийгддэг	22	3.25	.856
Шинэ зүйлийг байнга эрэлхийлдэг	22	3.93	.853
Шинэ бүтээл, санал дэмжин хэрэгжүүлдэг	22	3.50	.966
Компанид тогтсон дүрэм журам үйлчилдэг	22	3.18	.834
Ажилтан бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг	22	3.62	.885
Мэдээллийн солилцоо сайн явагддаг	22	3.62	.957
Ажил үүргийн хуваарь уян хатан байдаг	22	3.50	.894
Компанийн ажилчид багаар ажиллахдаа дуртай	22	3.81	.543
Шагнал урамшууллын систем сайн	22	3.06	.997
Эрхэм зорилго үнэт зүйлсээ тодорхолсон	22	3.43	1.15
Эрхэм зорилгодоо хүрэх хүсэл эрмэлзэлтэй	22	3.56	.813

Гарааны компани үүсгэн байгуулагч энтрепренер

Энтрепренер нь аз туршсан бизнест зориг шулуудан орох хүсэл эрмэлзэлтэй, зорилго нь үр дүнд чиглэсэн, асуудлыг шийдвэрлэх чадвартай, нөхцөл байдлыг мэдэрч шинэ зүйлийг санаачилж байдаг, шийдвэр гаргах чадвартай, багийн хамтын ажиллагааг илүүд үздэг шинж чанартай байдаг.³ Манай гарааны компаниудыг үүсгэн байгуулагч энтрепренерүүдийн зан төлвийг тодорхойлоход 16 үзүүлэлтүүдийн дундаж утга 3.5-4.3, стандарт хазайлт 0.3-1.1 гэсэн харьцангуй өндөр үзүүлэлт байгаа нь утгуудын хувьд тархалт их байгааг харуулж байна. Зан төлөвийг тодорхойлох үзүүлэлтүүд дотроос хамтран ажиллагчдаа итгэл хүлээлгэдэг 4.3, боломжийг эрэлхийлдэг 4.28, шийдвэр гаргах чадвартай 4.29, бусадтай хамтран ажиллах дуртай 4.18 гэсэн дундаж утгууд байгаа нь энтрепренерүүдийн зан төлөв, шинж чанартай нийцэж байгааг харуулж байгаа юм.

Хүснэгт 13. Энтрепренерийн зан төлвийн онцлог

Шалгуур үзүүлэлтүүд	N	Mean	Std. Deviation
Овсгоо самбаатай	22	3.81	.981
Золиос гаргах сэтгэлтэй	22	3.50	1.41
Боломжийг эрэлхийлдэг	22	4.28	.726
Манлайлал	22	4.12	1.02
Идэвхи санаачлага	22	4.18	1.04

3 An evaluation of Business start-up support for young people, Nigeal Meager, Peter Bates and Marc Cowling. 2003

Бусдадаа зөвлөгөө өгдөг	22	4.25	1.064
Хамтран ажиллагчдаа шударгаар ашгийг хүртгээдэг	22	4.06	1.181
Хамтран ажиллагчдаа итгэл хүлээлгэдэг	22	4.35	.606
Эрсдлийг даван туулах чадвартай	22	3.81	1.04
Шийдвэр гаргах чадвартай	22	4.29	.685
Өөрчлөлтөнд дасан зохицдог	22	4.18	.655
Шинийг эрэлхийлдэг	22	4.2353	.75245
Асуудалд бүтээлчээр ханддаг	22	4.0625	1.06262
Амбицтай	22	3.6875	1.01448
Бусадтай хамтран ажиллах дуртай	22	4.1875	.83417
Хошин шогийн мэдрэмжтэй	22	4.0714	1.07161

Дүгнэлт

Гарааны бизнес эрхлэх нь эрсдэл өндөртэй хэдий ч шинэ технологийг бий болгож ашиг олох маш том боломж байдаг. Манай улсын хувьд төр засгаас “Гарааны бизнес”-ийг дэмжих бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хууль эрхзүйн орчныг бүрдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой хэмжээнд шийдэж өгч байна. Мөн гарааны бизнес үүсгэн байгуулагчийн технологит суурилсан шинэ санааг оюуны өмчөөр баталгаажуулах, хамгаалах, ашиглах тал дээр чамлахааргүй ажил хийгдэж байгаа. Харин нэгэнт гарааны компани гэх босгыг даваад өөрийн гэсэн оюуны өмч, патенттэй, судалгааны байгууллагыг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нөхцөл байдлыг судлаж цаашид хамтран ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч чадахгүй байгаа нь учир дутагдалтай юм. Бид энэхүү судалгаагаараа гарааны компаниудын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлж, нөхцөл байдлыг илрүүлэхийг зорьсон.

Манай улсын Гарааны компаниуд давуу тал нь эзэмшиж буй оюуны өмчийн төрөл, тоо хэмжээ, компанид ажиллаж буй нарийн мэргэжилтэй ажилчид, эрдмийн зэрэг цолтой судлаачдын тоо хангалттай байна. Мөн үүсгэн байгуулагчдын хувь технологийн нарийн мэдлэгтэй, компани амжилттай авч явах хүсэл эрмэлзэлтэй байгаа зэрэг нь давуу тал болж байна. Харин технологи дамжуулалтыг бага хийдэг, их дээд судалгааны байгууллага болон томоохон компаниудтай хамтран ажилладаггүй, ажиллах нөхцөл боломж бага, санхүүгийн чадвар сул /нийт компаниудын 33,4% нь өөрийн хөрөнгөөр санхүүждэг/ г.м дутагдалтай талууд харагдаж байна.

Цаашид өндөр түвшний технологийг илүү дэмжиж ажиллах, судалгаа хөгжилд хөрөнгө оруулалт хийх, гадаадын венчур хөрөнгө оруулалтын компаниудтай хамтран ажиллаж хөрөнгө босго, компанийн менементийн тал дээр зөвлөх байгууллагуудаас зөвлөгөө авч ажиллах зэрэг боломжууд байна.

Судалгаагаар компаниудын борлуулалтын орлогын өсөлт, хөрөнгийн өсөлт, экспортын өсөлтийн хувь маш бага байгаа энэ нь цаашид удаан үргэлжилбэл “Гарааны компани” иуд хөрөнгийн эх үүсвэргүй болох, үйл ажиллагаа зогсох зэрэг тулгарч буй нийтлэг аюул, эрсдэл тулгарч болзошгүй байна.

Ашигласан материал

1. Пүрэвдагва.Х “Байгууллагын өөрчлөлтийн удирдлага” УБ 2012
2. Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо “Их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” УБ 2012
3. Хэнри Эцковиц “MIT ба энтрепренер шинжлэх ухааны үүсэл хөгжил” УБ 2014
4. Nigel Meager, Peter Bates and Marc Cowling “An Evaluation of Business Start-up Support for Young People” 2003
5. “Venture management” 2013
6. 벤처기업경영론, 무역경영사, 민경호, 2013
7. 년 기업가정신, 무역경영사, 민경호, 2009 년